

Эртний түрэг, уйгурын шашны холбогдолт зарим сурвалж, судар номын орчуулгын тухай

Ц.Баттулга* (МУИС)

0. Оршил

1. Эртний Түрэгийн үеийн шашны холбогдолт сурвалж
2. Эртний Уйгурын үеийн шашны холбогдолт зарим судар ном

0. Оршил

Монгол нутагт оршин тогтнож байсан эртний Түрэг угсаат улсууд олон зүйл үсэг бичиг хэрэглэж, мөн эдүй тэдүй ном, судар орчуулж байжээ. Тэд руни, уйгур бичгээс гадна согд, брахми, манихей, сири, төвд зэрэг үсгээр түрэг хэлээр шашны ном судар орчуулан туурвиж байсны нуталгаа их буй. Мөн хад чулуу, гэрэлт хөшөөний бичээснээ ч шашин ном дэлгэрч байсныг гэрчлэх баримт цөөнгүй. Харин тэдгээрийг манайд тухайлан судалсан нь бага, дурдах тэдүй байна.

Хүннү, Нирун (Сяньби), Жужан, Түрэг, Уйгур улсын үеийн орчуулга, тэдгээрийн онцлог зэргийг мэдэхгүйгээр Монголын орчуулгын түүхэн уламжлалын талаар өгүүлэх боломжгүй билээ. Тиймээс Түрэг, Уйгурын үеийн орчуулга, нэн ялангуяа шашны холбогдолт ном судрын орчуулгын талаар эрхбиш мэдэж байх учиртай.

Эртний Түрэг, Уйгурын үеийн шашны холбогдолт судар номыг дотор нь

1. Маани шашны холбогдолт судар ном
2. Бурхны шашны холбогдолт судар ном
3. Христын нестори шашны холбогдолт судар ном⁴¹ хэмээн хуваан үзэж болно.

Энэ нь зөвхөн судар номтой холбогдох ангилал бөгөөд чинагш түрэг хэлээрх Мани шашны холбогдолт судар номын орчуулга, түрэг хэлээрх Бурхны шашны холбогдолт судар номын орчуулга, түрэг хэлээрх Христын нестори шашны холбогдолт судар номын орчуулга, бас бусад номын (шашны бус) орчуулга гэх зэрэг бидний мэдэж судлах, монгол орчуулгатай харьцуулан үзүүштэй судалгааны эх хэрэглэгдэхүүн, сурвалж цөөнгүй байна.

1. Эртний Түрэгийн үеийн шашны холбогдолт сурвалж

Түрэгийн түрүү хаант улсын үед, тухайлбал Таспар хаан бурхны шашинтай байсныг нутлах хөдөлшгүй баримт Монгол нутгаас олдсон Бугатын гэрэлт хөшөө бөгөөд Түрэгүүдэд шашин ном согд, брахми үсэг, хэлбичгээр дамжин тархаж байсны нэгэн жишээ мөн болно. Бугатын гэж алдаршсан, яст мэлхийн суурьтай, хүүхэд хөхүүлж буй чоно дүрсэлсэн гурван талдаа согд, нэг талдаа брахми бичээстэйг хөшөөг археологич Ц.Доржсүрэн 1956 онд Архангай аймгийн Их Тамир сумын нутаг, сумын төвөөс 25 км-т Хойт

*МУИС-ийн ГХСС-ийн Түрэг судлалын тэнхим, профессор, доктор

⁴¹ Feriuh Ağca, Budist Türk çevresi metinlerinde olumsuzluk ve yokluk şekilleri, Ankara, 2010, s.29.

Тамирын голын зүүн цутгал, Баянцагаан голын баруун хөвөөнөөс олж илрүүлжээ⁴². Бугатын гэрэлт хөшөөний согд бичээсийг тайлж уншсан С.Г.Кляшторный, В.А.Лившиц нарын судалгаа орос, англи, түрк зэрэг хэлээр орчуулагдан гарчээ⁴³. Мөн түүнчлэн эл дурсгалын талаар М.Мори (Masao Mori)⁴⁴, Л.Базен (Louis Bazin)⁴⁵, О.Прицак (Omeljjan Pritsak)⁴⁶, Жан Поль Ру (Jean Paul Roux)⁴⁷, С.Чагатай (Saadet Çağatay), С.Тезжан (Semih Tezcan)⁴⁸ нарын эрдэмтдийн судалгаа, танилцуулга гарчээ.

Монгол-Японы хамтарсан “Бичээс” төслийн хүрээнд ажилласан эрдэмтэн Такао Мориясу (Takao Moriyasu), Тошио Хаяаши (Toshio Hayashi)⁴⁹ нар Бугатын гэрэлт хөшөөт тахилын цогцолбор, сүмийн археологийн судалгааны тоймыг, Ютака Ёшида (Yutaka Yoshida), Такао Мориясу нар согд бичээсийг дахин нягталж япон, англи хэлээр орчуулжээ⁵⁰. Уг гэрэлт хөшөөний брахми бичээсийг уншиж судалсан зүйл одоогоор байхгүй нь бичээс элэрч долрон унаснаас уншихуйяа нэн бэрх болсонтой холбоотой. Бугатын гэрэлт хөшөөний В II-ийн зургаадугаар мөрнөө “βуу мγ’n ty) [.....s](γ)wn pγwštγw δ’rt rty γγwšk sγδy (.) [...] (.w’št” (С.Г.Кляшторный, В.А.Лившиц нар), “β(γ)у м(γ)’[t]’t(p)’r x’γ’n] m(s) ++ [nβ] (y-r)’’k pγwštγw δ’rt rty xγ-(γw)šk sγδy (x) wt’w ’(kr) [ty]” (Ютака Ёшида, Такао Мориясу нар) гэж буй нь уг бичээсийн он цагийг тогтоох сэжиг болж байна.

Бичээст дурдагдаж буй гал туулай жил 559, 571, 583, 595, 607, 619 онуудад тохиолдох боломжтой бөгөөд энэ мэдээнд тулгуурлан уг гэрэлт хөшөөг 572 онд анх үйлдэж эхлээд юутай ч 580 оноос өмнө дурсгалыг бүтээж бүрэн дууссан гэж үздэг⁵¹. Зөвхөн эртний Түрэг төдийгүй Монгол газар дэлгэрсэн шашны түүхтэй холбоотой чухал мэдээ баримт буй тул нягтлан судлах, орчуулж нийтийн хүртээл болгох шаардлагатайг тэмдэглэе.

⁴² Ц.Доржсүрэн, 1956-1957 онд Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн тухай, Улаанбаатар, 1958.

⁴³ В.А.Лившиц, -Согдийская надпись из Бугута, - Олон улсын монголч эрдэмтний II их хурал, I боть, Улаанбаатар, 1973; С.Г.Кляшторный, В.А.Лившиц, -Согдийская надпись из Бугута, -Страны и народы Востока. Вып.10, Москва, 1971, стр.121-146; С.Г.Кляшторный, В.А.Лившиц, Открытие и изучение древнетюркских и согдийских эпиграфических памятников Центральной Азии, -Археология и этнография Монголии, Новосибирск, 1978, стр.37-60; S.G.Kljaštorniy & V.Livšic, The Sogdian Inscription of Bugut Revised, -Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Budapest, 1972, pp.69-102, +8 pls; S.G.Kljaštorniy, V.Livšic, Bugut’taki sogdça kitabe’ye yeni bir bakış, -Türk Dili Araştırmaları Yıllığı, Belleten 1987, Ankara, 1992, s.201-241, +14 pls; S.G.Kljaštorniy & V.Livšic, Une inscription inédite turque et sogdienne, -La stèle de Sevrey (Gobi méridional), Journal Asiatique 259-1/2, pp.11-20, + 3pls

⁴⁴ M.Mori, A New Materials on the Sogdians in the Tu-chüeh Empire, -Shigaku-Zasshi, LXXXI/ 2, February 1972, pp.77-86.

⁴⁵ L.Bazin, Turcs et Sogdiens: Les Enseignements de L’Inscription de Bugut (Mongolie), -Mélanges Linguistiques Offerts à Émile Benveniste, Collection Linguistique, publiée par la Société de Linguistique de Paris, LXX, Paris, 1975, pp.37-45.

⁴⁶ O.Pritsak, The Old Turkic Title “γwγ’p’nt””, -Studia Turcologica, Memoriae Alexii Bombaci Dicata, Napoli, 1982, pp.403-406.

⁴⁷ J.Paul Roux, Les inscriptions de Bugut et de Tariyat sur la religion des Turcs, --Studia Turcologica, Memoriae Alexii Bombaci Dicata, Napoli, 1982, pp.451-461.

⁴⁸ S.Çağatay, S.Tezcan, Tanıtımlar:Köktürk tarihinin çok önemli bir belgesi. Sogutça Bugut yazıtı, -Türk Dili Araştırmaları Yıllığı-Belleten 1975-1976, Ankara, 1976, s.245-252.

⁴⁹ 森安孝夫・林俊雄・ブグト遺蹟・モンゴル国現存遺蹟・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Takao Moriyasu, Toshio Hayashi, Site of Bugut, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 121.

⁵⁰ 吉田豊・森安孝夫・ブグト碑文・モンゴル国現存遺蹟・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Yutaka Yoshida, Takao Moriyasu, Bugut inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 122-125.

⁵¹ S.G.Kljaštorniy & V.Livšic, The Sogdian Inscription of Bugut Revised, -Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Budapest, 1972, pp. 73; S.G.Kljaštorniy, V.Livšic, Bugut’taki sogdça kitabe’ye yeni bir bakış, -Türk Dili Araştırmaları Yıllığı, Belleten 1987, Ankara, 1992, s.205-206.

2. Эртний Уйгурын үеийн шашны холбогдолт зарим сурвалж

Уйгурууд “altun önglög yaruq yaltrıqlıq qopta kötrülmiş nom iligi atlıq nom bitig), bodisataw taito samtso açarınıñ yorıqın uqıtmaq atlıq tsi in çuin tigmä k(a)wi nom bitig, abidarim koşavardi şastr, quan-şi-im pular, säkiz yümäk, linhua čäčäk üzäki itigi yaratiqi atlıq sudur nom bitig, amitaba- sudur, äryaräjävavädaka-sudur, maitrisimit, alqu ayıq yawız yollarıq artuqraq uz arıtdacı... uşnisa viçai atlıq darnı, mähamegha-sutra, mahopāya utlıyın yanturmiş sutur, kşanti qıluluy nom, kimqoqi, vajiracchetikā-sutra, tışastwustik, yitikān sudur, amitāyus-sutra, alqu ançolayu kälmişlärning uşnirlakşanlıntın ünmiş atlıq kötrlmış sitatapadra adı utsuqmaqsız darnı, prajñāparamitā, daşakırma budaawatanamal(a) nom bitig, lalitaristara-sutra, yoyārāyabhūmişastra, aymas, nañarjuna iligig otlägmä taqşut, jataka, iki yiltiz nom (Алтангэрэл, Авидармын тайлбар, Бодисатвад орохуй, Цагаан лянхуа судар, Майдар, Линхуа цэцгийн голтоос дэлгэрсэн алтан өнгөт судар, Очироор огтлогч судар, Долоон өвгөн одон нэрт судар, Аюуш, Цагаан шүхэртийн тогтоол, Билиг барамидийн судар, Нагаржунайн гэрээсэлсэн бичиг шаштир гэх мэт)” зэрэг 30 гаруй судар номыг уйгур хэлнээ орчуулсан ажээ.

Түүнчлэн төвд үсгээр уйгур хэлээр туурвисан судар ном ч буй билээ⁵². Тиймээс ч Зава Дамдины “Хорчойнжунг” сударт

1. ...Аяа тэр цаг-дор Уйгур Монголын аймаг нугууд
2. Аврал гурван эрдэнэ-дор итгэл одуулан тахиж
3. Алимад сүм дуган бүтээн, лагшин, зарлиг, тааллын шүтээн босгож
4. Ариун шагшаабадийг сахисан номын хүрээ олноор байгуулав
5. Тэр цагт тэд-бээр номлол сургаалийг уншихуй-дор
6. Тэгш босоо Согтаг үсгээр Энэтхэг хийгээд өөр өөрсдийн хэлийг хольж орчуулан
7. Тийн номлол, сонсгол, уншлага тэргүүтэнийг үйлдсэн үзэгдэнэ.
8. Тэрхүү шалтгаанаар эдүгээ ч бас нүүдэлчин монголын номын хэллэг-инү
9. Тэртээх Энэтхэг, Уйгур, Монголын хэл холилдон оршмуй.
10. Тийн бөгөөс Монголын үсэг бичгийг
11. Тэнцэшгүй Сажа Бандида-бээр зохиов хэмээсэн-инү
12. Тэсэл үгүйеэ эндүүрэлт яриа мөн болой.
13. Аливаа бас Монголын энэхүү төв нутаг-дор Согтаг нугууд
14. Алс Энэтхэг орноос Бүддийн шашины ёс хийгээд
15. Алимад наран ургах зүгээс Манихейн шашины ёс хоёрыг
16. Авч залан ирсэний дараагийн ул мөр болбоос
17. Аливаа Монголчуудын галын тахилга ба уулын тахилга хэмээх гарчээ...⁵³ хэмээн

тэмдэглэсэн ажээ.

Уйгур нар төр улсаа байгуулсан эхний хорь илүү жил руни бичгийг төрийн бичиг болгон хэрэглэж байсныг түүхийн олон баримт нутлан гэрчилнэ. Монгол нутгаас л гэхэд уйгур нарт холбогдох бичгийн цөөнгүй дурсгал олдсон нь уйгур нарын үсэг бичиг, соёл, хэл аялгууны чухаг баримт болох төдийгүй тухайн үеийн түүхэн хэрэг явдлыг тэмдэглэсэн түүхэн сурвалж болдогоороо нэн онцлогтой. Уйгурууд үсэг бичгээ солиход үндсэндээ хоёр хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж болох юм. Тан улсад Ань Лушан (安史之乱 an shi zhi luan)-ны бослого

⁵²Takao Moriyasu, Étude sur catechism bouddique ouïgour en écriture tibétaine (P.1.1292), Memoirs of the Faculty of Letters, Osaka University, Vol.XXV, Mart 1985, pp.1-85. (Япон хэлээр)

⁵³Ц.Шагдарсүрэн, Монгол бичиг буй болсон цаг хугацааны талаар эрэгцүүлэх учир холбогдол, “Монгол судлал, ЭШБ, МХСС, Улаанбаатар, 2010, Боть XXXI, (328), 128-р тал. (Заваа Дамдин, Хор чойнжунг зава (Умард зүгийн монгол ороона дээдийн ном эрдэнэ үүдэн гарсаны түүх цадиг өлзий хутагийн мүнхээх Лавайн эгшиг дуун хэмээх оршивай), Төвөдөөс орчуулсан тойн Лувсандаржаа, Улаанбаатар, 2007, (87 тал) 30-31-р тал.Ц.Шагдарсүрэн багшийн өгүүлэлээс дам эшлэв.)

гарч аргагүйтэхийн эрхэнд Уйгур нараас хаан нь тусламж гуйсан ажээ. Уйгурууд тэрхүү хүсэлт гуйлтыг ёсоор болгож 756, 757, 759, 762 онуудад цэрэг илгээж бослого хөдөлгөөнийг даржээ. Эл түүхэн үйл явдал уйгурууд улс төр, эдийн засгийн хувьд бэхжихэд ихээхэн нөлөөлсөн төдийгүй согдуудын худалдаа арилжаа эрх мэдэл нэмэгдэх шашин соёлын нөлөө ихсэх үндэс суурийг тавьжээ. Тэгээд ч 762 онд Бөгү хаан* Маанийн шашинт дөрвөн согд ламыг Орхон голын хөвөөнд орших их нийслэл Ордубалык (одоогийн Хар балгас)-т дагуулан ирж улмаар маанийн шашныг төрийн шашнаа хэмээн зарласан түүхтэй. Дээрхи түүхэн нөхцөл байдал уйгуруудын дунд суурьшмал соёл иргэншлийн эхлэлийг тавьснаар худалдаа арилжаа өргөжиж хот суурин газар Маанийн шашны сүм хийд баригдаж лам хувраг, номлогч нар олширч судар ном бичиг цаас арвидан дэлгэрчээ.

Бурханы болоод Маанийн шашны судар ном унших, эх (уйгур) хэлнээ орчуулан буулгах зайлшгүй шаардлага гарч руни бичиг нь үйс цааснаа бичих, ном судар орчуулан буулгахад тэр бүр бичгийн шаардлагыг төгс хангаж эс чадсанд шинэ үсэг зохиох, тэрхүү хэрэгцээг ном бичигт мэргэшсэн (согд) мэргэдийн туслалцаатайгаар шийдэх “тохироо бүрэлдэж” аандаа согд үсэгт дулдуйдаж суурилсан уйгур цагаан толгой, уйгур бичиг үүсчээ. Шашин ном дэлгэрүүлэхийн шалтгаанаар анх “сэтгэгдэн” үүдсэн эл бичиг тун удалгүй төр, түмний бичиг болж өөрийн “үндэсний хэв шинж”-ийг олж ихэд дэлгэрэн түгжээ. Хаан хийгээд хаант төрөөс ихэд тэтгэгдэн соёрхогдсон уйгур бичиг дэлгэрснээр руни бичиг аажмаар мартагдаж эхэлсэн бололтой⁵⁴.

Гэвч руни бичгийг тийнхүү асар богино хугацаанд орхигдож мартагдсан хэмээн үзэж огт болохгүй бөгөөд “төрийн бичиг” байхаа больсон ч багагүй хугацаанд сурч дадсан руни бичгээрээ бичсээр байсан ажээ. Түүний нэг нуталгаа нь Турфаны цуглуулгын руни бичигт ном судар юм. Дорнод Туркестаны Тэнгэр уулын бэл, Турфаны хотгорын газраас уйгурын түүх, соёлтой холбогдох асар их үнэ цэнэтэй өв илэрч улмаар Герман, Англи, Франц, Орос, Япон зэрэг улсын хээрийн шинжилгээний ангиуд 1890-1916 оны хооронд очиж судалгаа хийсэн түүхтэй. Тухайлбал, 1902-1914 оны хооронд Германы эрдэмтэн А.ф.Ле Кох (A.von Le Coq), А.Грунведел (A. Grünwedel) нарын нийт дөрвөн удаа удирдан зохион байгуулсан хээрийн хайгуул шинжилгээний ангийн ажлын хүрээнд олон арван бичгийн дурсгал олсон билээ. Тухайлбал, Хар Хожо хотыг малтан шинжлэх явцад руни, нангиад, сири, брахми, согд, төвд зэрэг 30-аад зүйлийн бичиг, 15 орчим хэлнээ туурвисан олон арван ном судар илрүүлжээ.

Энэхүү баялаг өвийн дотор руни бичгээр цаасан дээр бичсэн ном судар олдсон бөгөөд тэдгээр дурсгалууд эдүгээ Англи, Франц, Япон, Орос, Герман зэрэг орны томоохон номын сан, гар бичмэлийн цуглуулга, сан хөмрөгт хадгалагдаж байна.

Английн Стейн (Sir Aurel Stein)-ы цуглуулгад нийтдээ 12 хэсэг(№ 1-3. 8212/76; № 4. 8212/77; № 5-9. 8212/78; № 10. 8212/79; № 11. 8212/104; № 12. 8212/ 161) руни бичигт ном судар буй. Түүнээс хамгийн алдартай нь “Säkiz Yükmäk” болно.Säkiz Yükmäk хэмээх судрыг 1907 оны 11-р сарын 24-нд Турман (Турфан)-аас баруунш 10 км зайтай Ямазын хотгор хөндий\-ын Яар хотоос илрүүлсэн түүхтэй. Säkiz Yükmäксудар 405 хуудастай, № 11. 8212/104 дугаартай хадгалагдаж буй. Судрын оршилд нангиад хэлнээс орчуулсанаа

*Моюнчур хаан 759 онд нас барж, түүний орыг бага хүү Бөгү залгамжилж хаан ширээнд суужээ. Бөгү “Tengride bolnuš il tutnuš alp qutluu bilge (Тэнгэрт болгоогдсон улсыг хураасан баатар өлзийт мэргэн)” хаан цолтой байсан бөгөөд нангиад сурвалжид уг цолыг “Тэнгэрт төрж, улсаа удирдсан, баатар омголон хаан гэсэн утгатай” хэмээн тайлбарласан байна. Түүхэнд Бөгү хаан анх удаа шашны шинэтгэл хийснээрээ алдаршжээ.

Бөгү (759-779 оны хооронд төр барьсан) хааны (магадгүй) зарилгаар согд бичигт дулдуйдаж уйгур бичиг зохиосон нь, хожмын цагт Хубилай (1215-1294) хааны зарилгаар 1269 онд Пагва лам (“Phags-pa bla-ma) хэмээн алдаршсан Лодойжалцан (bLo-gros rgal-mchan 1234-1279) төвд үсэгт суурилан дөрвөлжин бичиг зохиосон, Тайзү хуанди (Тайзүн гэгээн соёлт хуанди буюу Цэцэн хаан, Дээд эрдэмт (Тянь зунг) 1627-1635 /1639-1644)-ийн зарлигаар Манж нар Эрдэнэ багш, Дахай оточ нар монгол бичигт (1627-1635 /1639-1644)-ийн зарлигаар Манж нар Эрдэнэ багш, Дахай оточ нар монгол бичигт тулгуурлан манж бичиг (Дусал бинтгүй бичгийн үе /1599-1632/, бүрнээ боловсорч төрийн бичиг болсон үе /1632-1911/) зохиосон нь цугаар үлгэр адил гэлтэй.

⁵⁴ Ц.Баттулга, Монголын руни бичгийн бага дурсгалууд, Тэргүүн дэвтэр, -Corpus scriptorum, Tom. I, Улаанбаатар, 2005, 34-37-р тал.

тодорхой өгүүлсэн байдаг. Уг судрыг герман, орос, англи, япон, хятад зэрэг хэлнээ бүрэн буюу хэсэгчилсэн орчуулсан байдаг.

Судрын зарим хэсгийг уйгур хэлнээ хэрхэн буулгасныг товч өгүүлбэл: Жишээ нь, Тийн мэдэхүйн найман чуулган (asta vijñana) རྣམ་ཤེས་ཚོགས་བརྒྱད། тухайд доорхи мэт буулгажээ.

1. Köz bilig- нүдний билиг (харах)
- нүдний тийн мэдэхүй རྩེ་རྣམ་ཤེས།
2. Kulgak bilig – чихний билиг (сонсох)
- чихний тийн мэдэхүй རྩ་བའི་རྣམ་ཤེས།
3. Til bilig – хэлний билиг (амтлах)
- хэлний тийн мэдэхүй རྩེ་རྣམ་ཤེས།
4. Burun bilig – хамрын билиг (үнэртэх)
- хамрын тийн мэдэхүй རྩེ་རྣམ་ཤེས།
5. Etüz bilig (< et + öz bilig)- махбодийн билиг (< мах + бие билиг "хүрэлцэх")
- биеийн тийн мэдэхүй རྩེ་རྣམ་ཤེས།
6. Köngül bilig – сэтгэлийн билиг (сэтгэл)
- сэтгэлийн тийн мэдэхүй རྩེ་རྣམ་ཤེས།
7. Adra-tigre bilig– Ялган салгах билиг
- нисваанист⁵⁵ тийн мэдэхүй རྩེ་རྣམ་ཤེས།
8. Anılık bilig – Язгуурын билиг
- хотол шүтээний тийн мэдэхүй རྩེ་རྣམ་ཤེས།

Уйгур орчуулгад “Нүдээр элдэв дүрс үзнэ. Дүрс өөрөө хоосон чанар. Хоосон чанар бол дүрс. Чихээр элдэв дууг сонсоно. Дуу өөрөө хоосон чанар. Хоосон чанар бол дуу юм. Хамраар элдэв үнэрийг үнэрлэнэ. Үнэр өөрөө хоосон чанар. Хоосон чанар бол үнэр юм. Хэлээр элдэв амтыг мэдэрнэ. Амт өөрөө хоосон чанар. Хоосон чанар бол амт юм. Биеэр элдэв хүрэлцэхүйг мэдэрнэ. Хүрэлцэхүй өөрөө хоосон чанар. Хоосон чанар бол хүрэлцэхүй юм. Оюун санаа өөрөө хоосон чанар. Хоосон чанар бол оюун санаа юм...” хэмээжээ.

⁵⁵Нисваанист сэтгэл རྩེ་རྣམ་ཤེས། нь мэдэхүйн найман чуулганы нэгэн. Хутагт мөрийг эс олохын зуур хотол шүтээний тийн мэдэхүйд зорин, насад би хэмээн барих, сэтгэлийн нисваанисаар түйдсэн, эш эс үзүүлсэн сэтгэл. Нисваанисын таван хор རྩེ་རྣམ་ཤེས།, Шунал тачаал རྩེ་རྣམ་ཤེས།, урин хилэн རྩེ་རྣམ་ཤེས།, эргүү мунхаг རྩེ་རྣམ་ཤེས།,

омог дээрэнгүй རྩེ་རྣམ་ཤེས།, атаа найдангүй རྩེ་རྣམ་ཤེས། эдгээр бөгөөд хураангуй нэр бөгөөд хүслийн эрдэм (дүрс, дуу, үнэр, амт, хүрэлцэхүй тав) бүхэнд тачааснаар шунал, би хэмээн баримтлахын оюунааар бусдал сэтгэлээсээ өслөхийг урин хилэн, мэдэгдэхүүн бүхэнд авах гээхийг эс мэдэж эргүүтэхийг мунхаг, бүхний дотроос би л хэмээн санаж, бусдыг доромжлон үзэх муу өдүүлбэрийг омог, өөртэйгээ адил сацуутныг сэжиглэн сонжиж, бусдын эрдэмд үл баярлах муу саналыг атаа хэмээн өгүүлэх ажээ. (Буддын шашин, соёлын тайлар толь, хоёрдугаар дэвтэр, Улаанбаатар, 1999, 123-р тал.)

Энэхүү 405 хуудастай судар номыг монгол хэлнээ орчуулж бусад орчуулгатай харьцуулж судлах аваас шашны ном судрын орчуулгын уламжлал, онцлог зэрэг олон зүйл тодорхой болох нь лавтай.

Мэргэ төлгийн энэ судрыг бүрэн эхээр нь монгол хэлнээ орчуулж бусад судартай харьцуулж үзвэл ихээхэн сонирхолтой судалгаа болох нь дамжиггүй.

“Орчуулгазүй” Боть 1, 2013

Турман (Турфан)-ны хөндийн Хар хотоос анх олсон 707 хуудас, эхлэлгүй Алтангэрэл судрыг В.Радлов, С.Е.Малов нар орчуулснаар судалгааны эргэлтэд оруулсан түүхтэй. Синку Сели Тутун хэмээгч “Табгач хэлнээс орчуулсан”-наа нэн тодорхой өгүүлжээ.

Уйгур “Алтангэрэл” сударт монгол хэлнээ өдгөө ч идвэхтэй хэрэглэгдэж байгаа *авшиг, авъяас, амбар, амраг, ананд, асури, балт, биширэх, бодисатва, бошиг, бурхан, буян, хилэнц, эрлиг, судар, санваар, нирваан, сансар* зэрэг нэн олон үг буй.

Төгсгөн тэмдэглэхэд,

- Түрэг угсаат улсуудын үеийн бурхны шашны холбогдолт сурвалж, судар номыг монгол хэлнээ орчуулах, судалгааг танилцуулах нь Монгол газар дэлгэрсэн шашны түүхийн судлалд чухал ач холбогдолтой;
- “Säkiz yükmäk”, “Altan yaruq” тэргүүт судар номыг эх бичгийн үүднээс судалж, энэтхэг (пали), нангиад, уйгур, төвд, монгол орчуулгатай харьцуулах нь зарим үгийг зөв таних, утгыг зөв ухахад нэн тустайгаас гадна уйгур хэлээр дамжин орж ирсэн “гэгдэх” үгс Монголчуудын уламжлалт шашин, соёлын судлалд ч чухал хэрэглэгдэхүүн болохыг онцлон тэмдэглэе.
- Орчуулагч өмнөтгөл бичдэг, ихэвчлэн “үгчлэн буулгах”-ыг эрхэмлэдэг байсан нь уйгур судар номын орчуулгын нэг гол онцлог юм.

бөлөгт төвд эхийг гол болгон, гучин нэгэн бөлөгт хятад, уйгур эхийг харгуулан орчуулсан тухайгаа төгсгөлийн үгэндээ тодорхой дурдсан байна. Монгол улсын Үндэсний номын санд одоогоор монгол үсгийн бар19, гар бичмэл11, тод үсгийн бичмэл4, төвд эхийн барын судар 7 хадгалагдаж буй ажээ.